



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Шар дэгд ӨЭМТ-ийн 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/170/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [nandinjargal@audit.gov.mn](mailto:nandinjargal@audit.gov.mn)

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 327734 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: Да.Отгонбаяр  
Утас: 315558 Цахим хаяг: [otgonbayarda@audit.gov.mn](mailto:otgonbayarda@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн:  
Бэст фортуна аудит ХХК-ийн захирал: Ж.Оюунцэцэг  
Утас: 324338, 89116465  
Цахим хаяг: [fortune2009audit@gmail.com](mailto:fortune2009audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,  
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 897  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ШАР ДЭГД ӨРХИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Ж.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Шар дэгд ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй, аудит хийх цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэсэн мөн нийт 11.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, нягтлан бодох бүртгэлийн олон улын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянгол дүүргийн Шар дэгд ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнээр тооцсон зардлын санхүүжилтээр 387.0 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 123.2 сая төгрөгийн, дархлаажуулалтын зардалд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 9.3

сая төгрөгийн, Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас 2.5 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажилласан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Баянгол дүүргийн Шар дэгд ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 94,2 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.4 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangu\Desktop\Бичиг хэргэ 2026\2026\word\ywsan bichig\Dugnell\_2026.docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
	2024-12-31	2025-12-31
<b>ХӨРӨНГӨ</b>		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	68,161.67	2,477,586.52
Дансны авлага	18,845.98	18,845.98
Татвар, НДШ-ийн авлага	-	787,888.87
Бусад авлага	43,658,985.67	5,167,759.90
Бусад санхүүгийн хөрөнгө	-	
Бараа материал	17,067,420.64	10,852,269.62
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	
Эргэлтийн хөрөнгийн дүн	60,813,413.96	19,304,350.89
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	101,782,850.10	93,122,637.52
Биет бус хөрөнгө	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	101,782,850.10	93,122,637.52
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>162,596,264.06</b>	<b>112,426,988.41</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	-	-
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	6,507,640.03	8,883,076.31
НДШ-ийн өглөг	5,589,786.80	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,097,426.83	8,883,076.31
Өр төлбөрийн нийт дүн	12,097,426.83	8,883,076.31
Эздийн өмч	25,015,309.14	25,015,309.14
Өмч: - төрийн	25,015,309.14	24,697,609.14
- хувийн	-	317,700.00
- хувьцаат	-	
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,046,268.40	1,046,268.40
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	124,437,259.69	77,482,334.56
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-
Эздийн өмчийн дүн	150,498,837.23	103,543,912.10
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>162,596,264.06</b>	<b>112,426,988.41</b>

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31	2025-12-31
Борлуулалтын орлого (цэвэр)	524,278,447.76	533,515,983.43
Борлуулалтын өртөг		-
Нийт ашиг ( алдагдал)	524,278,447.76	533,515,983.43
Бусад орлого	-	
Борлуулалт, маркетингийн зардал	504,412,764.58	580,470,908.56
Ерөнхий ба удирдлагын зардал	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)	19,865,683.18	-46,954,925.13
Татварын дараах ашиг (алдагдал)	19,865,683.18	-46,954,925.13
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	19,865,683.18	-46,954,925.13
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Орлогын нийт дүн	19,865,683.18	-46,954,925.13

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн/ тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023-12-31-ний үлдэгдэл	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	25,015,309.14	1,046,268.40	104,571,576.51	130,633,154.05
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	19,865,683.18	19,865,683.18
2024-12-31-ний үлдэгдэл	25,015,309.14	1,046,268.40	124,437,259.69	150,498,837.23
Залруулсан үлдэгдэл	25,015,309.14	1,046,268.40	124,437,259.69	150,498,837.23
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-46,954,925.13	-46,954,925.13
2025-12-31-ний үлдэгдэл	25,015,309.14	1,046,268.40	77,482,334.56	103,543,912.10

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	<i>/төгрөгөөр/</i>	
	2024-12-31	2025-12-31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	<b>462,555,462.09</b>	<b>549,365,542.53</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	462,555,462.09	549,365,542.53
Мөнгөн зарлагын дүн (-)	<b>462,503,251.14</b>	<b>546,956,117.68</b>
Ажиллагчдад төлсөн	204,022,489.67	431,764,385.96
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	74,860,996.00	75,122,170.18
Бараа материал худалдан авахад төлсөн	54,658,446.00	-
Ашиглалтын зардалд төлсөн	-	2,909,030.30
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	398,505.00	-
Татварын байгууллагад төлсөн	19,425,012.31	37,160,531.24
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	109,137,802.16	-
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>52,210.95</b>	<b>2,409,424.85</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	<b>996,900.00</b>	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	996,900.00	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(996,900.00)</b>	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>Валютын ханшийн зөрүү</b>	-	-
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(944,689.05)</b>	<b>2,409,424.85</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1,012,850.72	68,161.67
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	68,161.67	2,477,586.52

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,306,3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 72,1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 7,384.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 11,306.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, 2025 оны санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлээгүй, аудит хийх нөхцөл боломжоор хангаагүй тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2025 оны 2-р сарын цалинд өмнөх онд олгох байсан илүү цагийн хөлсийг ажилтанд олгосон. Өмнөх оны илүү цагийн хөлсийг санхүүгийн тайланд өглөгөөр харуулаагүй	1	- 446.4					1	446.4
Ажилтнуудад хавсран ажилласны нэмэгдэл цалинг олгохдоо тухайн хавсран ажиллаж байгаа албан тушаалын цалингаас тогтоосон хувиар тооцож олгох ёстой байтал тухайн нэмэгдэл цалин авч байгаа ажилтны өөрийнх нь албан тушаалын үндсэн цалингаас тогтоосон хувиар олгосон ба бүтэц орон тоо баталсан тушаал, хавсран ажиллах орон тооны тушаалд үндсэн цалинг тодорхой заагаагүй.	1	-					1	
Харилцах данснаас 2025.02.05 нд Дижитал Андмед ХХК программын төлбөр шилжүүлсэн боловч биет бус хөрөнгөнд бүртгээгүй	1	3,850.0					1	3,850.0
2025 оны 4-р сарын цалинг харилцахаар олгохдоо Э.Баасанжав, Б.Анужин нарт бодогдсон цалингаас илүү шилжүүлсэн.	1	72.1	1	72.1				
Санхүүгийн жилийн эцсийн тайланг хугацаа хоцроож 2026 оны 4 дүгээр сарын 10-нд аудитын байгууллагад ирүүлсэн	1				1			

**Нийслэлийн Баянгол дүүргийн Шар дэгд ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Шар дэгд ӨЭМТ-ийн харилцах данснаас 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдөр 2,790,000 төгрөг М.Мөнхжаргал, 05 дугаар сарын 06 ны өдөр 2,790,000 төгрөг О.Нямдаваа нарын зардал нийт 5,580,000.00 төгрөгийг Тэнгэр трэйвэл ХХК-ийн дансанд шилжүүлж, "Аялал жуулчлалын гэрээ" байгуулан аялалд явуулж, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан.	1	5,580.0			1	5,580.0		
2025.12.17 нд харилцах данснаас Арина Компьютерс ХХК д 1,804,200 төгрөг угаалгын машин авч ажилтнууд шагнасан	1	1,804.2			1	1,804.2		
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>11,752.7</b>	<b>1</b>	<b>72.1</b>	<b>3</b>	<b>7,384.2</b>	<b>3</b>	<b>4,296.4</b>